

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 14-ны өдөр

№ 25/26

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дах заалт, Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмын 6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/11 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зэргэлдээ компани болох “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай Хувьцаа барьцаалсан зээлийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, зах зээлийг тэлэх зорилгоор “Хамтран ажиллах гэрээ” байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах “Хамтран ажиллах гэрээ”-гээр “Инвескор Капитал ҮЦК” ХХК-д төлөх борлуулалтын шимтгэлийн хувь хэмжээг Компанийн бодлогод нийцүүлэн тогтоох бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, Хамтран ажиллах гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД


Ч. ХАШЧУЛУУН
Д. ЭНХБАТ
Ч. ӨНӨРЖАРГАЛ
Т. ТЭЛМЭН